

НИЙТИЙН ЗОРИУЛАЛТТАЙ УТАСГҮЙ СҮЛЖЭЭНИЙ ЦЭГИЙН 20 ... ОНЫ СУДАЛГАА

1. ХАЯГИЙН ХЭСЭГ

Дүүргийн нэр:

Хорооны дугаар:

код

1. Хорооны Засаг дарга жил бүрийн 12-р сарын 20-ны дотор дүүргийн ЗДТГ-т цахим хэлбэрээр хүргүүлнэ.
2. Дүүргийн ЗДТГ нь 12-р сарын 25-ны дотор Нийслэлийн Мэдээллийн технологийн газарт цахим хэлбэрээр хүргүүлнэ.
3. НМТГ нь мэдээллийг хороо, дүүргээр нягтлан шалгаж, 2-р сарын 20-ны дотор цахим хэлбэрээр НЗДТГ-т хүргүүлнэ.

2. МЭДЭЭНИЙ ХЭСЭГ

№	Нийтийн зориулалттай утасгүй сүлжээний цэгийн нэр, байршил	Интернэт түгээж буй компаний нэр	Хамрах хүрээ (кв.метр)	Тухайн байршилд авч буй интернэтийн хурд(Mbps)
А	Б	1	2	3
Дүн				

Шаардлагатай тохиолдолд ЭАБ-1 маягтын дагуу нэмэлт хуудсаар мэдээллийг цуглуулна.

Бүртгэсэн: Албан тушаал: _____ Гарын үсэг: _____ \

Хянасан: Албан тушаал: _____ Гарын үсэг: _____ \

Тамга\тэмдэг

Нийтийн зориулалттай утасгүй сүлжээний цэгийн бүртгэлийн маягт (ЭАБ-23)-ыг нөхөх заавар

Энэ бүртгэлийг хорооны ажилтан тухайн жилийн мэдээллийг 12 сарын 15-ны өдрөөр тасалбар болгон гаргаж, хорооны Засаг дарга тогтоосон хугацаанд дүүргийн ЗДТГ-т цахим хэлбэрээр, дүүргийн ЗДТГ нь бүртгэлийг хороо бүрээр хянаж баталгаажуулан дүүргийн хэмжээнд нэгтгэж, цахим хэлбэрээр Нийслэлийн Мэдээллийн технологийн газарт, НМТГ нь мэдээллийг хороо, дүүргээр нягтлан шалгаж, цахим хэлбэрээр НЗДТГ-т хүргүүлнэ.

1. ХАЯГИЙН ХЭСЭГ

Дүүргийн нэрийг бүтнээр бичиж, Багануур дүүрэг- **01**, Багахангай дүүрэг- **04**, Баянгол дүүрэг- **07**, Баянзүрх дүүрэг- **10**, Налайх дүүрэг- **13**, Сонгинохайрхан дүүрэг- **16**, Сүхбаатар дүүрэг- **19**, Хан-Уул дүүрэг- **22**, Чингэлтэй дүүрэг- **25** гэсэн кодыг зохих нүдэнд бөглөнө. Хорооны дугаарыг бичиж, кодыг "Хүн ам, өрхийн бүртгэлийн дэвтэр"-ийг нөхөх заавар болон "Хүн ам" мэдээллийн санг байгуулах заавраас харж нөхнө. Монгол Улсын засаг, захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн кодыг Нийслэлийн Статистикийн газар (утас 328787, 327946), дүүргийн Статистикийн хэлтсээс болон ubstat.mn цахим хуудсаас энэ кодыг мэдэх боломжтой.

2. МЭДЭЭЛЛИЙН ХЭСЭГ

Энэ маягтаар олон нийтэд зориулсан үнэ төлбөргүй, утасгүй интернетийн сүлжээ бүхий томоохон үйлчилгээний цэг, талбайг хамруулан бүртгэнэ. Утасгүй сүлжээ (Wireless networking) гэдэг нь хязгаарлагдмал хүрээнд 2 болон түүнээс олон компьютер эсвэл цахим төхөөрөмжүүд нь хоорондоо тархалтад долгион (spread-spectrum) буюу OFDM (Orthogonal frequency-division multiplexing) хувиргалтын технологи ашиглан утасгүй холбогдон мэдээлэл солилцохыг хэлнэ. Томоохон албан байгууллага, үйлчилгээний төв, талбайд Wi-Fi утасгүй интернет тавьж олон нийт үнэ төлбөргүй чөлөөтэй ашиглах болсон. Wi-Fi нь нууц үгтэй бол "олон нийтийнх" биш. Гэхдээ олон нийтийн үйлчилгээний газарт үйлчлүүлэгчид нууц үгийг чөлөөтэй хэлж өгч байгаа, эсвэл тухайн үйлчилгээний танхим, хоолны цэсэнд нууц үгээ бичсэн зэрэг тохиолдолд "олон нийтийнх" гэж тооцно.

Б баганад тухайн цэгийн оноосон албан ёсны нэр болон байршиж буй албан ёсны хаягийг бичнэ. Жишээ нь: Чингэсийн талбай, Жуулчны гудамж, Мэдээлэл технологийн үндэсний паркийн 1-р давхар, Тэнгис кино театр гэх мэт нэртэй байршил нь Ц.Жигжиджавын гудамж-9, Бага тойруу 15160 гэх мэт байна.

1-р баганад Тухайн цэгт интернет түгээж буй оператор компаний албан ёсны нэр, интернет түгээж буй хэрэгслэлийг эзэмшиж буй эзэмшигчийн нэрийг бичнэ.

2-р баганад Тухайн утасгүй интернет сүлжээ бүхий цэгийн хамрах талбайн хэмжээг тогтоож, квадрат метрээр (м²) бичнэ. Нэг байршилд хэд хэдэн утасгүй интернет цэг байвал тухайн цэг бүрийг бичиж, хамрах хүрээг тогтооно. Жишээ нь: Томоохон үйлчилгээний төвд байрласан ресторан, кафе, дэлгүүр тус бүрээр цэгийн нэрийг бичиж, байршил, хамрах хүрээг бичнэ.

3-р баганад Тухайн цэгт түгээж буй интернетийн хурдыг Mbps-аар тооцож бичнэ.

Тухайн хороонд нийтийн зориулалттай үнэ төлбөргүй, утасгүй интернетийн сүлжээ бүхий томоохон үйлчилгээний цэг, талбайн тоо их бол мэдээллийг маягтын дагуу нэмэлт хуудсаар нэтгэн гаргана.